



ДИГИТАЛ ЭРИН БА ХҮМҮҮСИЙН АМЬД ХАРИЛЦАА

Б.Булган

МУБИС-Багшийн сургууль, МХНУТ, доктор (Ph.D)
Холбоо барих зохиогч: bulgan@msue.edu.mn ORCID ID

Хүлээн авсан: 2026.03.01 Хянагдсан: 2026.04.06 Зөвшөөрсөн: 2026.05.18

Хураангуй

Өдгөө технологийн хурдацтай хөгжлийн нөлөөгөөр хүн төрөлхтний харилцааны хэв маяг, харилцааны экосистем эрс өөрчлөгдөж байна. Хүмүүсийн амьд харилцааны хэлбэр болох нүүр тулсан уулзалт, чин сэтгэлийн ярилцлага, баг, хэсгийн ажил, хамтдаа байх мэдрэмж, сэтгэлийн өнгө аяс, биеийн хэлэмж зэрэг нь цахим, платформд суурилсан харилцаагаар хэсэгчлэн солигдсоор байна. Энэ өөрчлөлт нь хүмүүсийн нийгэмшил, хүмүүншил, сэтгэл хөдлөл, өдөр тутмын ажил, амьдралд томоохон нөлөө үзүүлж байна.

Энэхүү өгүүллийн зорилго нь дижитал эринд хүмүүсийн амьд харилцааны чанар өөрчлөгдөж буйг тандан судалж, түүнд тулгуурлан, өөрчлөлтийн суурь шалтгаан, үр дагавар, арга замыг тодорхойлоход оршино.

Түлхүүр үг

Харилцааны экосистем, хүмүүсийн хүмүүншил, сэтгэл хөдлөл, харилцааны чанар, өөрчлөлтийн шалтгаан, үр дагавар

Удиртгал

Дижитал эринд технологи хөгжихийн хэрээр хувь хүний хөгжилд тавигдах шаардлага хувьсан өөрчлөгдсөөр байна. Мэдээлэл харилцааны технологиор дамжуулан, олон эх сурвалжаас авсан төрөл бүрийн форматтай мэдээллийг ойлгох, дижитал сүлжээг ашиглан харилцах, хамтран ажиллах, судлах, суралцах, зорилгодоо хүрэх, дижитал мэдээллийн системийг хөгжүүлэх мэдлэг, ур чадвар, хандлагатай болох (OECD, 2023) гэх зэргээр дижитал нийгэмд амьдрах, сурах, ажиллахад тохирсон мэдлэг, чадвар, хандлагыг томъёолон, дижитал чадамж, дижитал технологи, дижитал контент, дижиталжсан суралцахуй, багшлахуй, дижитал нийгмийн харилцаа гэх зэргээр үг бүр нь дижиталаар амьсгалж, үйл бүр нь технологиос хамааралтай болж байна. Бид үүнтэй зэрэгцүүлэн, “Монголчуудын уугуул мэдлэгийн тогтолцооны арга зүй болох амь ухаан, танин мэдэхүйн гурвал онол/гурамсан сэтгэлгээ, үзэл бодол болох арга билгийн сэтгэлгээ нь биднийг аливааг ухаж ойлгох, хийж гүйцэтгэхэд нөлөөлж, алив өөрчлөлтийн эсрэг



дархлааны систем болж өгч байдаг. Энэ дархлааны системээ л алдах юм бол бид дархлаагаа алдах болно” (Б.Жадамба 2022), “Монгол ардын сурган гэгээрүүлэх арга билиг нь дэлхийд гайхагдах өвөрмөц нэгэн үзэгдэл даруй мөн боловч үүгээрээ бахархах, үүнийгээ судлан хэрэглэх талаар олон жилийн турш олтгойтсоноос хүмүүс “монголоо алдлаа” гээд ихэд халаглан ярьцгаах болов” (Л.Түдэв 2002), “Өөрийн орны иргэдийн амьдралын хэвшил, соёлын онцлог байдал, монгол хүний сэтгэлгээний өвөрмөц шинжийг эхлэн судлан тогтоох нь чухал” (Н.Бэгз 2017) гэх зэрэг гүн нарийныг ухаж, цаад уг утгыг судалбал зохилтой үзэл санааг авч үзсэн болно.

Үндсэн хэсэг

Дижитал эринд харилцааны экосистем өөрчлөгдөгдсөөр байна. Өмнө нь хүмүүс хамтдаа байх, нэг орон зайд харилцах нь харилцааны гол хэлбэр байсан бол одоо орон зай, цаг хугацаанаас үл хамааран, уламжлалт бусаар буюу технологийн дэвшлийг ашиглан, нүүр нүүрээ харахгүйгээр, бие, сэтгэлээ мэдрэхгүйгээр харилцаж, хүмүүс хоорондын харилцааны шинэ хэлбэрийг бий болгосон. Энэ нь мэдээлэл солилцох хурдыг нэмэгдүүлдэг ч хүмүүсийн харилцаа, сэтгэл зүйн амин холбоонд сөрөг нөлөөтэй байна. Гэр бүлийн гишүүд нэг дор байгаа ч хүн бүр өөрийн гар утас, дэлгэцтэй, бие биетэйгээ харилцах нь багассаар байна. Амьд харилцаанд чухал нөлөөтэй сэтгэл хөдлөл, биеийн хэлэмж, нүдний харц, дууны өнгө, аялга зэрэг нь дижитал харилцаанд нөлөө нь бага байдаг. Эдгээр нь харилцааны утгыг бүтээх гол дохио тул технологи давамгайлахын хэрээр амьд харилцааны нарийн мэдрэмжүүд алдагдаж эхэлдэг. Үүнээс болж, буруу ойлголцол нэмэгдэж, сэтгэл зүйн дэмжлэг, итгэлцэл багасах магадлалтай.

Дижитал орчинд хүмүүс олон хүнийг мэддэг, дагадаг, олон пейж хуудас, групп, олон чатад нэгдсэн байдаг. Энэ нь мэдээллийн солилцоог өргөжүүлж байгаа ч сул холбоосыг нэмэгдүүлдэг. Үүнд дотно харилцаа, сэтгэлээ хуваалцах, бие биедээ итгэх, бие биеэ сонсох зэрэг харилцааны бүрдэл хэсгүүд багасдаг. Товчдоо, харилцаа өргөн хүрээтэй болж байгаа ч жинхэнэ дотно харилцаа багасна. Энэ нь хүмүүсийг олон сүлжээнд холбож байгаа мэт боловч ганцаардлыг бий болгох, гүнзгийрүүлэхэд хүргэнэ. Онлайн орчинд хүмүүс өөрийгөө шүүлтүүртэй, алдаа дутагдалгүй хувилбараар харуулах нь хүмүүст бусдын амьдралтай өөрийгөө харьцуулах, бодит амьд харилцаанд өөрийгөө нээхээс эмээх, итгэлцэл багасах хоёр үр дагавартай.

Дижитал эрин ба хүмүүсийн амьд харилцааны хамаарлын талаар олон эрдэмтэн мэргэд нарийвчлан судалж, өөрийн онол, үзэл баримтлалыг боловсруулсан байна. Тэдгээрээс Медиа экологийн онол, Сошиал капиталын онол, Баялаг медиа ба Сошиал оршихуйн онол, Өөрийгөө үзүүлэх онол зэргийг сонгож, уг өгүүллийн онолын үндэс болгов. Медиа экологийн онолоор дижитал эрин нь зөвхөн хэрэгсэл солигдсон үзэгдэл бус, хүмүүсийн харилцааны хэлбэрийг бүхэлд нь дахин бүтэцжүүлж буй экосистемийн өөрчлөлт юм. Уг онолоор “медиа бол мессеж” буюу хэрэглэж буй хэрэгсэл нь өөрөө харилцааны утга, чанарыг тодорхойлдог. Нүүр тулсан харилцаанаас текст, дүрс-суурьгай богино харилцаа руу шилжсэнээр хүний анхаарлын тогтворжилт, харилцааны гүнзгийрэл, биеийн хэлэмжийн

оролцоо эрс багасна. Ингэснээр амьд харилцаагүй болж, дижитал харилцааны хурд давамгайлж, харилцааны чанарыг хүний бие, сэтгэл бус, технологийн бүтэц тодорхойлох болсон нь өнөөгийн дижитал шилжилтийн нэг гол өөрчлөлт юм (M.McLuhan & N.Postman, 2019).

Харин Нийгмийн капиталын онолд “Нийгмийн капиталыг хүмүүс хоорондын итгэлцэл, дотно харилцаа, хамтын ажиллагаа бүрдүүлдэг. Дижитал орчинд үүсгэсэн хүмүүсийн харилцаа тооны хувьд өссөн ч чанарын хувьд гүн, нарийн биш болох хандлагатай байна. Өөрөөр хэлбэл, ойр дотно, найрсаг харилцаа буурч, өргөн хүрээний сул харилцаа нэмэгдсээр байна. Дижитал эрин нь нийгмийн капиталын бүтцийг чанарын хувьд өөрчлөх замаар амьд харилцааны чанарт нөлөөлж, харилцан итгэлцэл, халуун дулаан түншлэл, ойлголцол багасах шалтгаан болдог (Putnam & Bourdieu, 2025). Баялаг медиа болон Сошиал оршихуй онолоор “Харилцааны чанарыг харилцаанд ашиглаж буй хэлбэрийн баялаг байдлаар тодорхойлно. Нүүр тулсан харилцаа нь дохио зангаа, сэтгэл хөдлөл, биеийн хэлэмж, дууны өнгө зэргийг агуулдаг тул хамгийн баялаг медиа гэж үздэг. Харин чат, мессеж, эможи зэрэг нь мэдээллийн агуулга багатай тул баялаг бус медиад орно. Дижитал орчинд хүний дотоод сэтгэл мэдрэгдэх түвшин буурч, нүүр тулсан харилцааны халуун дулаан мэдрэмж, бодит оролцоо алдагдан, харилцааны гүн ойлголцлын түвшин буурдаг (Daft & Lengel; Short, Williams & Christie, 1986).

Дижитал орчин бол хүмүүс өөрийн “дэлгэцийн дүр”-ийг харуулах боломжтой орчин юм. Зураг, бичлэг, рийл зэрэг нь тодорхой зорилготой, бодит бус байдлаар засварлаж, өөрийгөө бусдад үзүүлэх тул бодит, амьд харилцаанаас зөрөх тохиолдол бий. Онлайнаар өөрийгөө илүү төгс, сонирхолтой, амжилттай харагдуулах эрмэлзэл дараа нь нүүр тулсан уулзалтад өөрийгөө нээх, итгэлцэл үүсгэх, бодитоор харилцахад саад болдог. Иймээс дижитал хэрэглээ ихсэх нь хүний жинхэнэ, амьд харилцааг гадна талаасаа “орлож буй” мэт боловч үнэндээ гүн утга, сэтгэлийн харилцааг сулруулдаг гэж дижитал эринд өөрийгөө үзүүлэх онолд дурджээ (E.Goffman 2018).

Эдгээр онолуудыг цогц байдлаар авч үзвэл, харилцааны экосистем өөрчлөгдөж (Media Ecology), хүмүүс хоорондын халуун дулаан харилцаа багасаж (Social Capital), дижитал харилцааны мэдээллийн баялаг байдал сул, хүмүүс бие биеийнхээ дотоод сэтгэлийг мэдрэхгүй болж (Media Richness & Social Presence), онлайн орчинд хүмүүс хиймэл дүр эсгэснээр жинхэнэ амьд харилцаа алдагдаж (Self-Presentation), ингэснээр дижитал эрин хүмүүсийг “холбож байгаа мэт боловч амьд харилцааны чанарыг бууруулах”-д давхар нөлөө үзүүлж буйг баталж байна.

Судалгааны арга зүй

Дижитал эринд өссөн хүүхдүүд ихэвчлэн мэдээллийг богино хугацаанд хүлээн авч, олон эх сурвалжаас зэрэг мэдээлэл олж боловсруулахад чадвар, хурдтай байдаг ч хүмүүстэй харилцах, өөрийгөө илэрхийлэх зэрэгт хурдтай байж чаддаггүй нь ажиглагддаг. Ийнхүү сүүлийн үед харилцааны чанар зарим талаар амьд бус, тодорхойгүй болох шинж илэрч байна. Үүнийг нийгэм судлаачид хосолмол харилцааны хэлбэр хэмээн тодорхойлдог бөгөөд цахим харилцаа ба нүүр тулсан харилцаа зэрэгцэн оршин, харилцан нөлөөлдөг цогц бүтэц гэж тайлбарладаг.



Үүнийг илрүүлэх зорилгоор Багшийн сургуульд 2025-2026 оны хичээлийн жилд элсэн, “Багш, бага боловсрол” хөтөлбөрөөр суралцаж буй I курсийн 118 оюутнаас асуулга судалгаа авч, задлан шинжилгээ хийсэн болно.

Асуулга 1. Дижитал эриний давуу ба сул тал нь чамд яаж мэдрэгддэг вэ?

Оюутнуудын өгсөн хариултыг тоон үзүүлэлттэй нь харьцуулж үзэхэд цахим орчны давуу тал нь сул талаас цөөн байна. Нийт 276 удаагийн давтамжаас хамгийн өндөр хувийг эзэлсэн гурван давуу талыг харуулбал:



- Нэг дор олон талын мэдээлэл авах боломжтой - 46%
- Шинэ мэдээлэл авах боломжтой - 26%
- Эрэл хайгуул хийх тохиромжтой - 21%

Эдгээр 3 үзүүлэлт нь нийт давуу талын 93%-ийг бүрдүүлж байна. Энэ нь оюутнууд цахим орчныг юуны өмнө мэдээлэл олж авах гол эх сурвалж, суралцах үйл явцыг дэмжих хэрэгсэл гэж ойлгодог нь дийлэнх оролцогчдын хариулт нэг чиглэлд байгаагаас харж болно. Бусад давуу талууд 0-7% хооронд хэлбэлзэж байгаа нь тэдгээр нь оюутнуудын хувьд хоёрдогч ач холбогдолтой болохыг нотолж байна.



Харин сул талын хувьд огт өөр дүр зураг ажиглагдсан. Нийт 218 удаагийн давтамжаас харахад нэг хоёр зүйл давамгайлахаас илүүтэй маш олон янзын асуудал харилцан адилгүй түвшинд илэрсэн.

- Хэт их хэрэглээ, донтох эрсдэл - 18%
- Найдваргүй мэдээлэлд автах эрсдэл - 17%
- Эрүүл мэндийн хүндрэл, нүдний ядрал - 14%
- Сэтгэл зүйн тогтворгүй байдал, сэтгэл санаагаар унах - 10%
- Анхаарал сарних, цаг үрэх - 13%

Үүнээс гадна үлдсэн хувь нь хэрэглээтэй холбоотой жижиг боловч олон асуудлууд руу тархсан байдаг. Өөрөөр хэлбэл, сул талын хариултууд 10 гаруй өөр төрлөөр тархсан нь цахим хэрэглээ оюутнуудын амьдрал ахуй, эрүүл мэнд, сэтгэл зүй, аюулгүй байдал, нийгмийн харилцаа, сургалтын чанар, цагийн менежмент зэрэгт нөлөөлж байгааг илтгэнэ. Харьцуулалт хийж үзвэл:

Давуу тал нь 3 үндсэн чиглэлд төвлөрч, нийт хариултын дийлэнх буюу 276 давтамжийн 93%-ийг эзэлж байна. Харин сул талд хамаатай 218 давтамж маш олон жижиг хэсгүүдэд хуваагдсан бөгөөд хамгийн өндөр хамаарал ердөө 18%-тай байна. Энэ нь сул талууд өргөн хүрээтэй, олон талтай, хариултууд нь тархай, задгай байгааг харуулж байна. Энэхүү тоон харьцаанаас харахад оюутнууд цахим орчны эерэг талуудыг бүгд ижил түвшинд өдөр тутамд хэрэглэж мэдэрдэг, харин сөрөг нөлөө нь хүн бүрт өөр өөр хэлбэрээр илэрдэг нь тодорхой байна.

Асуулга 2. Дижитал эриний давуу ба сул тал танд ямар нөлөөлөл үзүүлж байна гэж боддог вэ?

Судалгаанд оролцогчдын үнэлгээг нэгтгэхэд дижитал орчны давуу талын нийт оноо 146, харин сул талын нийт оноо 139 гэсэн дүн гарсан нь хоёр талын зөрүү маш бага, ердөө 7 нэгжийн давуу талтай байгааг харуулж байна. Давуу талын онооны дотор хамгийн өндөр төвлөрөл нь 61 оноог бүрдүүлсэн нэг томоохон давуу үзүүлэлт дээр хэт төвлөрсөн байв. Дараагийн түвшний үзүүлэлтүүд нь 23-24 орчим оноотой хэсэгт багтаж, үлдсэн давуу талын үзүүлэлтүүд нь 5-16 хооронд хэлбэлзэж байна. Энэ нь хэрэглэгчид технологийн ашиг тусыг тодорхой цөөн гол хүчин зүйлд илүү тод мэдэрдэг, харин бусад давуу талууд харьцангуй бага давтамжтай илэрдэг гэдгийг илтгэнэ.

Харин сул талын онооны хувьд хамгийн өндөр үзүүлэлт 30 байсан бол түүнээс арай нам үзүүлэлтүүд нь 16-24-ийн хооронд төвлөрсөн бөгөөд эрүүл мэнд, анхаарал төвлөрөл, харилцаанд нөлөөлөх асуудлууд харьцангуй ойролцоо түвшинд үнэлэгджээ. Үлдсэн сул талууд нь 3-13-ийн хооронд багцлагдаж, олон төрлийн жижиг сөрөг нөлөөллүүд нийлж, нийт 139 оноог бүрдүүлсэн байна.

Тоон өгөгдлөөс харахад давуу болон сул талын хуваарилалт чанарын хувьд ялгаатай байна.

- Давуу талууд цөөн тооны хүчтэй хүчин зүйлд төвлөрсөн, өндөр давтамжтай үзүүлэлт давамгайлдаг.
- Сул талууд олон төрлийн асуудалд сарнисан, бага ба дунд түвшний олон хүчин зүйл нийлж, нийт оноог бүрдүүлсэн.

Үүний үр дүнд хоёр талын нийлбэр харьцангуй ойролцоо гарсан ч давуу талын томоохон үзүүлэлтүүдийн нөлөөгөөр нийт онооны зөрүү давуу талын талд бага зэрэг хэлбийсэн байна.




Асуулга 3. Дижитал эриний сул талын нөлөөллийг даван туулах ямар арга зам байна вэ?

№	Хариултын чиглэл	Давтамж	Хувь
1	Цагийн менежмент гаргаж зохицуулах	30	22.6%
2	Өөрийгөө хянах чадвар	13	9.8%
3	Мэдээллийг илүү шүүх, нягтлах, унших	12	9.0%
4	Дотны хүмүүстэйгээ биечлэн уулзах	11	8.3%
5	Хүүхдэд багаас нь цахим орчны үр дагаврыг тайлбарлан ойлгуулах	11	8.3%
6	Орон даяар зөв цахим хэрэглээний хөдөлгөөн өрнүүлэх	20	15.0%
7	Хичээл сургалтад технологийг хязгаарлах	14	10.5%
8	Өөрийн цахим орчны нууцлалыг хадгалах	10	7.5%
9	Утасны хэрэглээг багасгаж, ном унших, спортоор хичээллэх	5	3.8%
10	Утсанд буй хэрэгцээгүй апп-ыг устгах, татахгүй байх	3	2.3%
11	Дүрэм батлан хэрэгжүүлэх	1	0.75%




Судалгаанд оролцогчид цахим хэрэглээнээс шалтгаалах төрөл бүрийн нөлөөллийг нэрлэсэн бөгөөд эдгээр хариултууд нийт 133 давтамжтайгаар илэрчээ.



Хариултын тархалтаас харахад хамгийн их давтагдсан нэг үзүүлэлт нийт хариултын 22.6%-ийг эзэлсэн нь судалгаанд оролцогчдын хамгийн нийтлэг мэдэрсэн нөлөөг илтгэнэ. Үүний дараагаар 9-15%-ийн хооронд багтах нөлөөллүүд багцлан гарсан нь олонх оролцогч цахим хэрэглээтэй холбоотой дундаж түвшний зөрчил, дарамт, ядрал зэрэг мэдрэмжүүдийг хэлж буйг харуулж байна. Харин нийт хариултын 1%-иас бага хувийг эзэлсэн олон жижиг давтамжууд нь хувь хүний онцлог, хэрэглээний хэв маягаас шалтгаалах цөөн төрлийн нөлөөлөл нийт дүнг бүрдүүлж байгааг илтгэв.

Асуулга 4.

Судалгаанд ирүүлсэн 177 хариултын тоон үзүүлэлтүүд дараах байдалтай байна.



Судалгааны дүнгээс харахад дижитал хэрэглээ, технологийн нөлөө нь хүний боловсрол, хөгжилд дунд болон өндөр эерэг нөлөөтэй гэж оролцогчдын олонх нь үнэлсэн байна.

Хамгийн олон буюу 54 (30.5%) нь дунд зэрэг буюу 3-р түвшний нөлөөтэй гэж үзжээ. Үүний дараа 49 (27.7%) нь 4-р түвшний эерэг нөлөөтэй гэж үнэлсэн байна.




Мөн 15 (8.5%) нь маш сайн буюу 5-р түвшинд үнэлсэн нь технологийн дэвшил нь хүний хөгжилд бодитой дэмжлэг үзүүлдэг гэж үзжээ.

Нөгөө талаас, 8 (4.5%) нь маш бага нөлөөтэй (1-р түвшин), 10 (5.6%) нь бага нөлөөтэй (2-р түвшин) гэж дүгнэсэн нь технологийн хэрэглээ бүх хүнд адил үр дүнтэй нөлөөлдөггүй, зарим нь хангалттай ашиглаж чаддаггүй эсвэл сөрөг талуудыг илүүтэй хардаг байж болохыг илтгэнэ. Оролцогчдын 66%-д технологи эерэг нөлөөтэй (3-5-р түвшин) 10%-д сул нөлөөтэй (1-2-р түвшин) байна. Ингэснээр дижитал орчин, технологийн хэрэглээ нь хүний суралцах, хөгжих үйл явцад дэмжлэг үзүүлдэг гэсэн хандлага зонхилж байна гэж дүгнэв.

Асуулга 5.

Хариултын чиглэл	Давтамж
Гэр бүлийн орчин	54
Нийгэм, хүмүүсийн харилцаа	40
Сургууль, багш нар	6
Өөрийн эргэцүүлэл, ухаарал	5
Найз нөхдийн хүрээлэл	1
Технологийн зөв, зорилготой хэрэглээ	1
Ном бүтээл унших, логик сэтгэлгээ	2
Хүмүүсийн мэдрэмж, онцлог, хэрэгцээг ойлгох чадвар	1
Бусдын тусч, шударга зан чанар	1



Суралцагчдын хувьд хүн шиг хүн болж төлөвшихөд хамгийн хүчтэй нөлөө үзүүлсэн хүчин зүйл нь нэгдүгээрт, нийт 94 давтамжтайгаар гэр бүл хамгийн өндөр хувь эзэлсэн нь хувь хүний хүмүүжил, ёс суртахууны анхдагч эх үүсвэр гэр бүлийн орчин хэвээр байгааг харуулж байна. Энэ нь бусад бүх хүчин зүйлсийг нийлүүлсэн дүнгээс даруй хэд дахин өндөр байгаа нь хүүхдийн зан төлөв, үнэт зүйлсийн суурь гэр бүлийн соёл, хүмүүжлийн арга барилаас голлон шалтгаалдгийг

нотолж байна.

Үүний дараах нөлөөлөл нийгэм, хүмүүсийн харилцааны орчин, сургууль, багш нар, өөрийн эргэцүүлэл, ухаарал зэрэг нь тогтвортой боловч гэр бүлийн нөлөөтэй харьцуулахад харьцангуй бага хувь эзэлж байна. Энэ нь хүүхдийн хүмүүншлийн хоёрдогч орчин болох нийгэм-сэтгэл зүйн орчны нөлөө чухал болохыг харуулсан. Харин найз нөхдийн хүрээлэл, технологийн зөв, зорилготой хэрэглээ, ном бүтээл унших дадал, хүмүүсийн мэдрэмж, онцлог, хэрэгцээг ойлгох чадвар, бусдын тусч, шударга зан чанар гэх мэт хувь хүний гадаад, дотоод орчны нөлөөллүүдийг дурдсан байна. Энэ нь суралцагчид өөрийн хүмүүжилд хувь хүний хүчин зүйлс болон соёлын жижиг орчин нөлөөтэйг онцолжээ.

Энэхүү судалгаанаас харахад хүний мэдлэг, мэдээллийн хэрэглээ, нийгмийн харилцаа хоорондоо нягт холбоотойг харуулж байна. Орчин үеийн нийгэмд интернэт, дижитал платформууд нь мэдээллийг хялбар олж авах боломж олгодог ч тэдгээр мэдээллийг ялгах, боловсруулах чадвар чухал хэвээр байна. Хүнд мэдээллээс илүү бусадтай харилцах, бие биеэ ойлгох, хайрлах, энэрэх нь нэн чухлаас гадна хүмүүс хоорондын амьд харилцааны явцад хүн болж, хөгжиж, туршлага хуримтлуулдаг болохыг судалгаанд оролцогчид чухалчилжээ. Гэр бүл, сургууль, багш нар, найз нөхөд, нийгмийн орчин нь хувь хүний мэдлэг, зан төлөв, суралцах үйл явцад эерэг нөлөө үзүүлж, мэдээллийг зөв ашиглахад дэмжлэг болдог нь тодорхой байна.

Судалгааны үр дүн

Оюутнуудын хувьд дижитал хэрэглээний бодит байдал эерэг ба сөрөг нөлөө зэрэгцэн оршин буй дүр зурагтай байна. Олон оюутан хичээлийн дараа цахим орчинд байхыг илүүд үздэг бөгөөд мэдээлэл хайх, хичээлд бэлтгэх, тоглоом тоглох, сошиал орчинд харилцах зэрэг үйлдэл нь тэдний амралт, танин мэдэхүйн орон зайг бүрдүүлдэг гол арга зам болоод байна.

Гэхдээ цахим хэрэглээ нь оюутнуудын танин мэдэхүйг тэлж, мэдээлэлд боловсруулалт хийх чадварыг сайжруулж, өөрийн сонирхол, чадварт тохирсон эх сурвалжтай ажиллах, дуртай сэдвээ судлах, хичээлийн даалгаврыг бие даан гүйцэтгэх, зураг, видео бүтээл хийх зэргээр өөрийгөө хөгжүүлэх боломжтой байна. Гэвч хэрэглээ хяналтгүй үед нойр алдагдах, царай зүс алдах, анхаарал сарних, дижитал донтолт үүсэх, биеийн хөдөлгөөн багасах зэрэг эрсдэл ихэссэн байна. Цахим хэрэглээг хориглох бус, харин зөв, зохистой хэрэглээнд сургах нь илүү үр дүнтэй.

Дүгнэлт

Дижитал эрин нь хүмүүсийн харилцааг хялбарчилж, мэдээллийн хүртээмжийг өргөжүүлэн, бие даан сурах, мэдээлэлд өргөн хүрээтэй хандах, цаг хугацаа хэмнэх зэрэг эерэг нөлөөтэй ч амьд харилцааны чанарт сөрөг нөлөө үзүүлж буй олон талт үйл явц юм. Өөрөөр хэлбэл, хүмүүс хоорондын харилцаанд эв ээтэй, амь нэгтэй, амьд харилцааг сулруулах, нойр, амралтын хэмнэл алдагдуулах, сэтгэл зүйн дарамт үүсгэх, өөрийгөө илэрхийлэх хэлбэрийг зохиомол болгох хандлагыг бий болгоход хүргэж байна. Иймээс цаашид технологийн хэрэглээг тэнцвэртэй болгох, гэр бүл,



сургуулийн орчинд нүүр тулсан харилцааг илүү чухалчлах, дижитал дүр ба бодит би-гийн ялгааг таньж мэдэх, нийгмийн дотно харилцааг сэргээх бодлого зайлшгүй шаардлагатай байна. Багш нар хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, сайжруулах үйл явцдаа дижитал эриний суралцагчдын онцлог, хэрэгцээг харгалзах нь сургалтын чанарт нөлөөлөх нэг хүчин зүйл болохыг анхаарвал зохино.

Талархал

Тус судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсэн Багшийн сургуулийн “Багш, бага боловсрол” хөтөлбөрөөр суралцаж буй I курсийн оюутнуудад чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Ном зүй

1. Бэгз, Н. (2017). Боловсролын хөгжлийн онол, арга зүйн асуудлууд. Улаанбаатар:
2. Жадамба, Б. (2017). Амь амьдрахуй ухаан. Улаанбаатар: Гэрэлт судар ХХК.
3. Түдэв, Л. (2002). Бүтээлийн чуулган XXIII боть. Улаанбаатар: Уриа ХХК.
4. OECD. (2023). *OECD Digital Education Outlook 2023*. <https://www.oecd-ilibrary.org/content/publication/c74f03de-en>
5. Spante, M., Hashemi, S. S., Lundin, M., & Algers, A. (2018). Digital competence and digital literacy in higher education research: Systematic review of concept use. *Cogent Education*, 5(1), 1519143.



DIGITAL ERA AND HUMAN FACE-TO-FACE COMMUNICATION

B. Bulgan
MNUE . Teachers School. Department of Mongolian
Language and Social Sciences, doctor (Ph.D)
Corresponding author: Email ID @msue.edu.mn ORCID ID

Received: 2026.03.01

Reviewed: 2026.04.06

Accepted: 2026.05.18

Abstract

Today, under the influence of rapid technological development, the patterns and ecosystem of human communication are changing significantly. Forms of living human interaction—face-to-face meetings, sincere conversations, teamwork, a sense of being together, emotional tone and body language—are increasingly being partially replaced by digital, platform-based communication. This change has a considerable impact on people’s socialization, humaneness, emotions, daily work and everyday life. The purpose of this article is to explore how the quality of human face-to-face communication is changing in the digital era and, on this basis, to identify the underlying causes, consequences and possible ways forward.

Keywords

communication ecosystem, humaneness, emotional expression, communication quality, causes of change, consequences
